

Мөнгө, санхүүгийн статистикт өөрчлөлт оруулах тухай

Олон улсын стандарт болон олон улсын байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу мөнгө, санхүүгийн статистик үзүүлэлтүүдэд дараах өөрчлөлтүүдийг 2008 оны 1-р сараас 2017 оны 5-р сарын тоон үзүүлэлтүүдэд тусгав.

1. Татан буугдсан банкуудын иргэд, байгууллагуудаас татсан харилцах, хадгаламжийн үлдэгдлийг үйл ажиллагаа нь зогссон үеүүд дэх 2010 оны 5-р сараас 2016 оны 4-р сар хүртэлх хугацаанд нийт мөнгөний нийлүүлэлтээс 1.0 саяас 3648.8 сая хүртэлх төгрөгийг хасав.
2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад экспортын чиглэлтэй жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэхэд олгох хөнгөлөлттэй зээл болон Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлүүдийг Монголбанкаар дамжуулан зээлдүүлж, төслөөс санхүүжигдсэн зээлийн эх үүсвэрийг хадгаламжийн байгууллагуудын тоймд Төв Банкны гадаад пассив болон хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр баганад бүртгэж байсныг (Монголбанк Засгийн газар хоорондын дамжуулан олгох төслийн зээлийн гэрээнд 2017 оны 7-р сарын 20-ны өдөр өөрчлөлт орсноор) Засгийн газарт өгөх өглөгт оруулан бүртгэлээ. Улмаар Хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр дэх дүнгүүдийг арилгаж, Төв Банкны урт хугацаат гадаад пассив 3.1-4.7 тэрбум төгрөгөөр буурч, Засгийн газрын хадгаламж 18.7-28.7 тэрбум төгрөгийн хооронд өсчээ.

Дэлгэрэнгүй тоон мэдээллийг хүснэгтээс харна уу.

